

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2013 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2014.03.26

Улаанбаатар

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 5 дугаар сарын 07-ны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны жилийн ажлын тайланд Хорооны даргын 2014 оны 07 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг үнэлгээ хийлээ.

Үнэлгээг Хууль зүйн яамнаас боловсруулан гаргасан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дотоодын үнэлгээний хэлбэрийг сонгож гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2013 онд Монгол улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгасан зорилтуудын холбогдох заалт, УИХ-ын тогтоол, Байнгын хорооны хуралдааны тогтоол, тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар, Хорооны 2012 оны 04 дүгээр сарын 24-ны 117 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны 2012-2016 оны үйл ажиллагааны стратеги зорилт”-ын хүрээнд Хорооны хэмжээнд нэгтгэсэн байдлаар 79 ажил төлөвлөн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан ба нийт газар, хэлтсүүд 334 ажил төлөвлөн хийж гүйцэтгэсэн байна .

Тайлант хугацаанд Хорооны төлөвлөгөөний биелэлтийн явцыг 4 удаа нэгтгэн гаргаж, тухай бүр Хорооны удирдлагуудад танилцуулсан байна.

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулах ажлыг Хорооны ажилтнууд болон мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг хэлбэрээр 1 удаа зохион байгуулсан байна.

2013 онд Авлигатай тэмцэх газраас Төрийн 120 байгууллагын авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхэд Санхүүгийн зохицуулах 69 оноогоор 6 дугаар байрт шалгарсан амжилтыг үзүүлсэн байна.

I. Үнэлгээний чиглэл болон холбогдох мэдээлэл:

1. Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэг

Хороо 2013 онд Үнэт цаасны газар, Даатгалын газар, Бичил санхүүгийн газар, Тамгын газар, Эрсдэлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний газар болон Дотоод хяналтын хэлтэс, Компанийн засаглалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх алба гэсэн бүтэцтэй, **116** ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулсан байна.

Хорооны бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт болон нэгжүүдийн чиг үүргийг 2011 оны 172 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан бөгөөд “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай”, “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай”, “Хөдөө аж

ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай”, “Жолоочийн даатгалын тухай”, “Зээлийн мэдээллийн тухай”, “Зээлийн батлан даалтын сангийн тухай”, “Хөрөнгө оруулалтын сангийн тухай”, “Хөрөнгө оруулалтын тухай” зэрэг хуулиуд шинээр батлагдсанаар Хорооны үйл ажиллагааны хамрах хүрээ болон зохицуулалтад хамрагдах байгууллагуудын тоо нэмэгдэж байгаа тул цаашид бүтэц зохион байгуулалт, чиг үүрэгт өөрчлөлт оруулах, оновчтой болгох зайлшгүй шаардлагатай байна.

2. Хэрэгжүүлж буй чиг үүргийн агуулга

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу чиг үүргийн хэрэгжилтийг гаргавал:

Тайлангийн хугацаанд салбарын хэмжээнд хэрэгжиж буй Монгол Улсын 9 хууль, бодлогын 4 баримт бичиг, дээд газрын 13 тогтоол шийдвэрийн биелэлтийг 4 удаа гаргаж УИХ-ын Тамгын газарт хүргүүлсэн байна.

Мөн УИХ-ын гишүүдээс нийт 14 санал, хүсэлт ирүүлсэн ба шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2010 оны 50 дугаар захирамжийн дагуу улирал бүр хүргүүлсэн байна.

Тайлант онд Хорооны 26 удаагийн хуралдаанаар 568 асуудал/тайланд давхардсан тоогоор дурьдагдсан/хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргасан нь өмнөх онтой харьцуулахад хэлэлцсэн асуудлын тоо 17.2 хувиар өссөн байна. Хэлэлцсэн асуудлын тоог салбараар авч үзвэл Бичил санхүүгийн газраас 299, Үнэт цаасны газраас 135, Даатгалын газраас 67, Эрсдлийн үнэлгээ судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний газраас 58 асуудлыг Хорооны хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлсэн байна.



2006-2013 онуудад Хорооны 153 удаагийн хуралдаанаар 2872 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.



2013 онд 143 тусгай зөвшөөрөл шинээр олгож, 194 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 1 тусгай зөвшөөрлийг сэргээж, 22 тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 21 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

2013 оны жилийн эцсийн байдлаар Хорооны хяналт, зохицуулалтад Үнэт цаасны зах зээлийн 425 хуулийн этгээд, 1178 иргэн, Даатгалын зах зээлд 51 хуулийн этгээд, 3299 иргэн Бичил санхүүгийн зах зээлд 404 хуулийн этгээд, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлээр 100 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байна.

Хорооны хэмжээнд Улсын ерөнхий байцаагч 1, улсын ахлах байцаагч 13, улсын байцаагч 51, нийт 65 байцаагч ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд хянан шалгагч нар Улсын ерөнхий байцаагчийн баталсан хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө, удирдамжийн дагуу хэсэгчилсэн болон иж бүрэн хэлбэрээр, дангаар болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран нийт 608 зохицуулалтын байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийжээ.

Тайлант хугацаанд зохицуулалтын байгууллагуудын 2012 оны жилийн эцэс, 2013 оны улирлын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг “Fin-A” системээр авч зайны хяналт шалгалтыг 1589 удаа хийж, дүгнэлт гаргасан байна.

2013 оны жилийн эцэст Хадгаламж зээлийн хоршоод, Банк бус санхүүгийн байгууллагууд, Даатгалын компаниуд, Брокер, диллерийн компаниуд болон мэргэжлийн оролцогчдын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан болон аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг “Fin-A” системээр цахимаар хүлээн авсан байна.

Зохицуулалтад хамрагдах нийт 980 гаруй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд жилийн ажлын төлөвлөгөөний дагуу зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг хэрэгжүүлж, газар дээрх шалгалтад нийт хуулийн этгээдийн 18.6 хувийг хамруулж, хууль тогтоомж зөрчсөн 68 тохиолдолд албан шаардлага хүргүүлэн, 113 захиргааны арга хэмжээ авч, хугацаатай үүрэг даалгавар өгсөн байна. Үүнд: Үнэт цаасны газар 25, Бичил санхүүгийн газар 28, Даатгалын газар 12, Эрсдлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний газар 3 албан шаардлага зохицуулалтын байгууллагуудад хүргүүлсэн байна.

Улсын байцаагчдаас 186.9 сая төгрөгийн торгууль, шийтгэврийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа 139 зохицуулалтын байгууллага, тэдгээрийн 147 салбарт газар дээрх хяналт, шалгалт хийх болон сургалт семинар зохион байгуулах ажлыг Хорооны орон нутаг дах төлөөлөгчдөөр дамжуулан хуваарийн дагуу зохион байгуулсан байна.

Тайлант онд давхардсан тоогоор Хорооны 53 ажилтан 109 удаа орон нутаг дах зохицуулалтын байгууллага, тэдгээрийн салбарт томилолтоор ажилласан байна.

Хорооны орон нутаг дахь төлөөлөгчдийн ээлжит семинарыг зохион байгуулан 2012 оны ажлын тайлан, шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжууд, санхүүгийн салбарын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлыг хэлэлцэн, хууль, журмын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудаас үзүүлэх үйлчилгээг сайжруулах, сурталчлах, иргэдийг мэдээллээр хангах талаар чиглэл өгч ажилласан байна.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2011 оны 04 дүгээр сарын 12-ны 28 дугаар хурлын тэмдэглэлд: “... Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх шаардлагатай уялдуулан Хороо болон түүний дэргэдэх Хяналтын зөвлөлийн эрх, үүргийг өргөтгөх, бие даасан байдлыг бэхжүүлэх, ялангуяа Хорооны төлөөллийг орон нутагт орон тооны болгох, төсөв санхүүжилтийн бие даасан байдлыг нь хангах зэрэг чиглэлээр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлан боловсруулах”, 2013 оны 12 дугаар сарын 10-ны 30 дугаар хурлын тэмдэглэлд: “...Банк бус санхүүгийн үйл ажиллагааг алслагдмал орон нутгийн иргэдэд хүргэх хүртээмж хязгаарлагдмал хэвээр байгааг анхааралдаа авч, тэдгээрийн үйлчилгээний хүрээг тэлэх зохицуулалтын оновчтой бодлого боловсруулж, орон нутагт тохирсон банк бус санхүүгийн үйлчилгээний шинэ загвар бүтээгдэхүүн нэвтрүүлэх, бичил санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга механизмыг сайжруулах, Төв банктай хамтран ажиллах” гэж заасны дагуу болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа зохицуулалтын байгууллагууд, тэдгээрийн салбарын тоо эрс өсч байгааг харгалзан Хорооны жил бүрийн төсөвт шаардагдах зардлын

тооцооллыг тусгаж холбогдох байгууллагуудад хүргүүлдэг боловч өнөөг хүртэл уг асуудал шийдвэрлэгдээгүй байна.

Тайлант онд иргэдээс 323 өргөдөл, байгуулагаас 8820 албан бичиг хүлээн авч, 4898 албан бичиг гадагш явуулж, бичиг хэргийн нийт эргэлт 14041-д хүрсэн байгаа нь 2012 онтой харьцуулахад бичиг хэргийн эргэлт 10.5 хувиар өссөн, шийдвэрлэх асуудлын тогтмол нэмэгдсэн гэсэн үзүүлэлт гарч байна.



2013 онд Захиргааны 5 хэргийн, Иргэний 4 хэргийн шүүхэд нийт 15 удаа тайлбар, шүүх хуралдаан хойшилсонтой холбоотой 10 хүсэлт, нотлох баримт гаргуулах тухай 5 хүсэлтийг шийдвэрлэсэн байна.

Тайлант онд хууль тогтоомжийг сурталчилах, санхүүгийн зах зээлд оролцогчид, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн зах зээлийн сургалт, сурталчилгааг сайжруулах, хүртээмжтэй болгох зорилгоор Хорооны Тамгын газрын бүтцэд Санхүүгийн боловсрол, сургалт сурталчилгааны хэлтсийг шинээр байгуулсан байна.

2013 онд давхардсан тоогоор 30 телевиз, өдөр тутмын 3 сонин, 3 вэб сайтад Хорооны үйл ажиллагааны талаарх 46 мэдээ, мэдээллийг гаргаж, нийтэд танилцуулсан байна.

3. Үйл ажиллагаа явуулж буй байдал

2013 оны жилийн ажлын төлөвлөгөөний биелэлт 96 хувьтай, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлээгүй шалтгаанаар 2 удаагийн сургалт, 1 удаагийн хэлэлцүүлэг болон зарим судалгааны ажлууд хугацаандаа хийгдээгүй байна.

Тайлант оны эцэст Хорооны газар, хэлтсүүдийн хийсэн ажлын тайланг хуваарийн дагуу хэлэлцэж, дүгнэлт гарган, цаашид анхаарах асуудлаар санал зөвлөгөө өгөх ажлыг тогтмол зохион байгуулж байгаа нь сайшаалтай боловч уг ажлыг Тамгын газрын нэг ажилтан дангаар хариуцан гүйцэтгэж байгаа нь шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

Иймд цаашид ажлын төлөвлөгөө, тайланд өгөх, үнэлгээг боловсронгуй болгох, төлөвлөгөө, тайлангийн боловсруулалтыг сайжруулах, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх, хяналтыг сайжруулах зорилгоор хяналт, шинжилгээ хариуцсан тусгайлсан нэгж байгуулан ажиллах нь илүү үр дүнтэй болно.

Тайлангийн хугацаанд газар, хэлтсүүдээс 1600 хадгаламжийн нэгж хүлээн авч бүртгэн архивт шилжүүлсэн бөгөөд оны эцсийн байдлаар Хорооны архивт 7479 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. Орон байрны хүрэлцээ муугаас шалтгаалан байгууллагын архив, бичиг баримтын хадгалалт стандартын дагуу зай талбайд хадгалагдахгүй байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

Хорооны стратегийн төлөвлөгөөнд тусгагдсан цахим архив бий болгох бэлтгэл ажлын хүрээнд 2013 онд архивын баримтын тооллого хийх, данс бүртгэлийг шинэчлэх, баримтын боловсруулалтын байдалд судалгаа хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Тайлант онд Хорооны хуралдааны 546 тогтоол, 10 тэмдэглэл, Хорооны даргын 300 тушаал, Улсын Ерөнхий байцаагчийн 19 тушаал, Ажлын албаны даргын 248 тушаалаар нийт 1123 асуудлыг шийдвэрлэсэн байна.

2013 онд өссөн дүнгээр эрхлэх асуудлын хүрээнд төрийн 5 байгууллага, 6 мэргэжлийн холбоод, 4 төрийн бус байгууллага, 1 хэвлэл мэдээллийн байгууллага, 5 гадаадын байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулж зарим чиглэлд ажлын ахиц гарч байгаа боловч цаашид холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн үр дүнг сайжруулах шаардлагатай.

4. Ажилтнуудын талаарх мэдээлэл

2013 онд хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн хүрээнд гадаадын их дээд сургуульд магистрын зэрэг олгох сургалтад 12, дотоодын их дээд, сургууль, академид 3 ажилтныг тус тус суралцуулснаас гадна нийт ажилтнуудыг хамарсан “Байгууллагын шинэчлэл өөрчлөлт”, “Олон нийтийн харилцаагаар дамжуулан мэдээлэл түгээх болон олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж, Люксембургийн Вант улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Санхүүгийн салбарыг бэхжүүлэх болон сургалтын төсөл”-ийн хүрээнд англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж нийт 42 ажилтныг хамруулснаас гадна шинээр ажилд орсон ажилтнуудад зориулсан “Чиглүүлэх сургалт”-ыг 2 удаа зохион байгуулсан байна.

2013 онд хүний нөөцтэй холбоотой асуудлаар Хорооны даргын 22, Улсын ерөнхий байцаагчийн 18, Ажлын албаны даргын 140, нийт 180 тушаал гарсан байна.

2013 оны жилийн эцсийн байдлаар Хорооны хэмжээнд төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвтэй 58 албан хаагч ажиллаж байна.

Боловсролын түвшингээр нь авч үзвэл доктор 3, магистр 44, бакалавр 64, тусгай дунд боловсролтой 2, бүрэн дунд боловсролтой 2, бүрэн бус дунд боловсролтой 1 ажилтан байна.

Мэргэжлийн хувьд 58.6 хувь нь санхүү, эдийн засгийн мэргэжилтэй, 16.4 хувь нь эрх зүйч, 25 хувь нь бусад мэргэжлийнх байна.

Насны ангиллаар 23-35 настай 66, 36-50 настай 41, 50-с дээш настай 9 ажилтан, хүйсийн хувьд эрэгтэй 51, эмэгтэй 65 ажилтан байна.

Төрийн албанд ажилласан хугацааны хувьд 1-3 жил хүртэл 44, 5 жил хүртэл 9, 5-аас дээш жил ажилласан 63 ажилтан байна.

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу гадаадад сурахаар төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 11, хүүхэд асрах чөлөөтэй 5 ажилтан байна.

Цаашид хүний нөөцийн талаар баримтлах бодлого боловсруулж, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн албаны мэргэшсэн баг бүрдүүлэх чиглэлд онцгой анхаарч, ажилтнуудын нийгмийн асуудлыг шат дараатай шийдвэрлүүлэх нь зүйтэй.

5. Эрх зүйн болон бусад орчин нөхцөл

2013 онд Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиуд батлагдаж, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулсан бөгөөд, салбарын зарим хуулиудын төслийг шинээр боловсруулах, холбогдох журам, зааврыг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хүрээнд нийт 60 журам, заавар боловсруулан гаргасан нь өмнөх онтой харьцуулахад 57 хувиар өссөн нь дээрх хуулиуд шинээр батлагдан гарсантай шууд холбоотой байна.

2013 оны байдлаар Хорооны үйл ажиллагаанд шууд хамааралтай дараах хуулиудын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Үүнд: “Валютын зохицуулалтын тухай”, “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай”, “Хоршооны тухай”, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай”, “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай”, “Даатгалын тухай”, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай”, “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай”, “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай”, “Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай”, “Жолоочийн даатгалын тухай”, “Компанийн тухай”, “Зээлийн мэдээллийн тухай”, “Хадгаламж зээлийн хоршооны тухай”, “Зээлийн батлан даалтын сангийн тухай”, “Үнэт цаасны зах зээлийн тухай”, “Хөрөнгө оруулалтын сангийн тухай”, “Хөрөнгө оруулалтын тухай” зэрэг хуулиуд болно.

Дээрх хуулиудтай дагалдан гарсан 168 журам, заавар, аргачлал, дүрмийг мөрдөн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд салбараар нь ангилж үзвэл Бичил санхүүгийн салбарын зохицуулалтын чиглэлээр 42 журам, Үнэт цаасны салбарын зохицуулалтын чиглэлээр 43 журам, Даатгалын салбарын зохицуулалтын чиглэлээр 67 журам, Эрсдлийн үнэлгээ судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлээр 16 журмыг тус тус мөрдөн ажиллаж байна.

Цаашид шинээр буюу шинэчлэн батлагдсан хуулиуд болон дагалдан гарсан журам, заавруудын хэрэгжилтийг бүрэн хангах, боловсронгуй болгох шаардлагатай.

Хорооны цахим хуудасны хэвийн найдвартай ажиллагааг хангаж, мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн, англи, монгол хэлээр нийт 350 мэдээ, мэдээллийг оруулсан байна.

Мэдээллийн технологийн сургалт явуулах, сүлжээний тоног төхөөрөмж, мэдээлэл, мэдээллийн сан, бусад системийн аюулгүй байдлыг хангах, "Fin-A" системийн технологи, үйл ажиллагаа, арга зүйн ба албажуулалтын хүрээг сайжруулах шаардлагатай.

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор <http://mnt.frc.mn/> цахим хуудас болон 261662 дугаарын утсыг тогтмол ажиллуулж байна.

Мөн Хорооны ажилтнуудад зориулсан дотоод цахим хуудсыг шинээр нээсэн нь мэдээллийг шуурхай солилцох нөхцлийг бүрдүүлж, ажлын ачааллыг багасгах чиглэлд ахиц гарсан оновчтой шийдэл болж чадсан байна.


6. Ажилтнуудын ажлын ачаалал

Хорооны үндсэн чиг үүргийг хариуцан ажиллаж байгаа нэгжүүдэд нийт ажилтнуудын 62 хувь нь ажиллаж байгаа бөгөөд Бичил санхүүгийн газрын нэг ажилтан 24-32, Үнэт цаасны газрын нэг ажилтан 26-42 зохицуулалтын байгууллага тус тус хариуцдаг, нэг ажилтан жилд 115 албан бичиг, өргөдөл гомдолтой танилцаж 73 албан бичигт хариу хүргүүлдэг, Хорооны хуралд 8-27 асуудал боловсруулж танилцуулдаг, 40 орчим хууль журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг, газар дээрх хяналт шалгалтын ажилд 3-11 удаа оролцож тайлан гаргадаг, Бодлогын хэлтсийн ажилтнуудын хувьд 4-5 хууль, журмын төслийг дангаар болон хамтарч боловсруулдаг зэрэг дундаж үзүүлэлтүүд гарч байгаа тул нэг ажилтанд ногдох ажлын ачаалал “Их” гэсэн үнэлгээ гарч байна.

Дээрх үзүүлэлтүүдийг салбараар авч үзвэл Бичил санхүүгийн салбар болон Үнэт цаасны салбар хариуцсан ажилтнуудын хувьд хариуцсан ажилтны ажлын ачаалал маш их буюу дундаж үзүүлэлтээс дээгүүр байгаа тул цаашид ажлын ачаалал, хүний нөөцийн хуваарилалтыг оновчтой болгох шаардлагатай.

7. Төсөв, хөрөнгө

Хорооны дүрмийн 5.4-т “Хороо өөрийн орлогыг аажмаар нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийг бууруулах зарчмыг баримтална” гэж заасан бөгөөд 2006 оноос хойшхи хугацаанд дээрх зарчмыг бүрэн хангаж ажиллан 2013 оны орлогын төлөвлөгөөг 94 хувиар 660,9 сая төгрөгөөр давуулан биелүүлж, батлагдсан төсвийг 4.2 хувь буюу 88 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.



Орлогын хэмжээ сүүлийн жилүүдэд өссөн үзүүлэлттэй байгаа нь зохицуулалтын байгууллагын тоо өссөн, тэдгээрт тавих хяналт зохицуулалт сайжирч байгааг харуулж байна.

Хорооны жил бүрийн улсын төсөвт төвлөрүүлж буй орлого буюу Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөгжүүлэх чиглэлд зарцуулах талаар харилцагч, үйлчлүүлэгчдээс гаргасан удаа дараагийн санал, хүсэлтийг судалж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар санал боловсруулан шийдвэрлүүлэх шаардлагатай.

Төсвийн орлогын төлөвлөгөөг жил бүр давуулан биелүүлж байгаа боловч Хорооны төсвийг батлахдаа хөрөнгө оруулалттай холбоотой саналыг удаа дараа шийдвэрлээгүйн улмаас ажилтнуудын албан хэрэгцээний нийт компьютерийн 75 хувь элэгдлээ бүрэн нөхөж ашиглалтын хугацаа дууссан, 52 хувь нь хүчин чадлын хувьд шаардлагад нийцэхгүй байгаа бөгөөд 20 хувь нь файлын шүүгээгүй, зарим ажилтнууд түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг, хэт олноороо суудаг, өрөө тасалгааны хангамж, хүрэлцээ муу, стандартаас хэт доогуур үзүүлэлттэй байгаа зэрэг нь ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж, эрсдэл дагуулж болзошгүй байна.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2011 оны 04 дүгээр сарын 12-ны 28 дугаар хурлын тэмдэглэлд. “...Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх шаардлагатай уялдуулан Хороо болон түүний дэргэдэх Хяналтын зөвлөлийн эрх, үүргийг өргөтгөх, бие даасан байдлыг бэхжүүлэх, ялангуяа Хорооны төлөөллийг орон нутагт орон тооны болгох, төсөв санхүүжилтийн бие даасан байдлыг нь хангах зэрэг чиглэлээр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлан боловсруулах”, “...Хорооны үйл ажиллагаанд шаардлагатай байгаа байр, тоног төхөөрөмж, иргэд, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн төвийн барилга, санхүүгийн мэдээллийн технологийн шинэчлэл, боловсон хүчний сургалт, дадлагажилт зэрэг асуудлуудад шаардагдах хөрөнгийн тооцоо судалгааг гаргаж 2011 оны

төсвийн тодотголд болон 2012 оны төсөвт тусгуулах талаархи саналаа Засгийн газар, Улсын Их хуралд ирүүлж шийдвэрлүүлэх” гэж заасны дагуу шаардагдах төсвийн тооцооллыг гаргаж жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган холбогдох байгууллагад хүргүүлдэг боловч уг асуудлыг шийдвэрлэхгүй байсаар өнөөг хүрсэн байна.

I. Санал, дүгнэлт

Тайлант онд Хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах нэгдсэн бодлого боловсруулах, зохицуулалтад хамрагдах байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, хянах, иргэд, хөрөнгө оруулагчид, үйлчлүүлэгчдийг мэдээллээр хангах, сургах чиглэлээр тавьсан зорилтоо бүрэн хангаж ажилласан байна.

Цаашид ажлын хүртээмж, чанарыг дээшлүүлэх чиглэлээр анхаарвал зохих асуудлаар ажлын хэсгээс дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Хорооны хэвийн үйл ажиллагааг явуулахад зайлшгүй шаардлагатай байгаа иргэд, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн төвийн барилга, санхүүгийн мэдээллийн технологийн шинэчлэл, боловсон хүчний сургалт, дадлагажилт, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл, орон нутгийн төлөөлөгчдийг орон тооны болгох асуудлуудад шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар УИХ-ын байнгын хорооны хуралдааны тэмдэглэлд заасан шийдвэрийг өнөөг хүртэл шийдвэрлүүлж чадаагүй хугацаа алдаж байгаад онцгой анхаарч дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллах;

2. Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, сургалт, сурталчилгааны чиглэлээр хийж байгаа ажлуудыг эрчимжүүлэх;

3. Зах зээлийн судалгаанд үндэслэсэн хяналт зохицуулалтыг бий болгох зорилгоор судалгаа хариуцсан нэгж байгуулах;

4. Мэдээллийн программтай болох, хадгалагдаж байгаа мэдээллийн аюулгүй байдлыг хангах асуудлыг цогцоор нь шийдвэрлэх;

5. Энэхүү тайланд дурьдагдсан бусад асуудлуудыг анхааралдаа авч хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах.

АЖЛЫН ХЭСЭГ